

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
2019 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 02

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	“БҮТГ” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	<p>Мон – Энержи Консалт ХХК-тай хамтран Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлыг эрчимжүүлж ЭХЯ-аас цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах, зураг төслийн ажлыг дуусгахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тус паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг авах асуудлыг Эрчим Хүчний Яамны Сайдад тавьж, техникийн нөхцөлийг олгуулахаар болсон бөгөөд 2019.11.22-ны өдөр Яамны Шинжлэх ухаан технологийн хурлаар цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгох асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн боловч 2019.12.03-ныг хүртэл хойшлогдов.</li> <li>- “Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газраас Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн батлагдсан Ерөнхий төлөвлөгөөг дахин нягталж тодотгол хийсэн. Уг тодотголын дагуу “Мон Энержи Консалт” ХХК нь зураг төсөлд нэмэлт өөрчлөлтийг оруулан засварлаж батлуулсан.</li> <li>- “Мон-Энержи Консалт” ХХК нь паркийн инженерийн шугам сүлжээний цахилгаан хангамжаас бусад зураг төслийг батлуулахаар Барилга хөгжлийн төвд хандан магадлалын экспертыг томилуулсан. Одоогоор зураг төсөл магадлалаар хянагдаж байна.</li> </ul>	100%
2	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	<ul style="list-style-type: none"> <li>- Паркийн “Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилгын зураг төслийн гүйцэтгэгчээр “Нутаг консалтинг” ХХК шалгарч, нийслэлийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан. “Нутаг консалтинг” ХХК-тай 2019.11.07-нд уулзалт зохион байгуулан зураг төсөл хийгдэх 1067 м2 газрыг танилцуулж, тус газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайлан буюу шаардлагатай</li> </ul>	100%

		<p>материалаар ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Захиргаа, нэгдсэн үйлчилгээний барилгын зураг төслийн ажлын даалгаврыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас баталсан бөгөөд ажлын даалгаварт тусгагдсанаар паркийн "Үйлдвэрийн албан контор"-ын гэж нэрлэхээр болсон.</li> <li>- Нутаг консалтинг компанийн удирдлага 2019.11.22-нд газар дээр ажиллан эскиз зургийг зөвшилцөн баталгаажуулж, уг барилгыг барих талбайн хөрсний бүтцийн шинжилгээ хийх зорилгоор 2 цооног өрөмдөж дээж авах ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан.</li> <li>- Мөн Үйлдвэрийн конторын барилгын газарт байр зүйн зургийг хийсэн бөгөөд барилгын эскиз зургийг батлуулахаар Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт хүргүүлээд байна. Эскиз зураг батлагдсанаар техникийн нөхцөл авах ажлыг эхлүүлнэ.</li> </ul>	
3		<p>"Санни трейд" ХХК-иас 2019.11.14-нд урьдчилсан байдлаар ирүүлсэн Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан"-тай танилцаж, шаардлагатай тодруулга өгөх зорилгоор паркийн инженерүүд уулзаж нэмэлт тодотгол хийж, Ерөнхий төлөвлөгөөг хүргүүлсэн.</p> <p>2019.11. 28-нд эцсийн байдлаар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг "Санни трейд" ХХК-иас ирүүлсэн бөгөөд гүйцэтгэлийн түвшин 100% байна.</p> <p>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам"-ын дагуу орон нутгийн иргэдэд танилцуулан иргэдийн нийтийн хурал, иргэдээр хэлэлцүүлэн санал авч тусгах шаардлагатай байдаг тул Багануур дүүргийн 5 хорооны Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид болон иргэдэд танилцуулан санал авах ажлын бэлтгэлийг хангаж байна.</p> <p>Мөн паркийн зүгээс тайланд өгөх саналаа боловсруулж байна.</p>	100%
4	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6.5	<p>"Багануур тохижилт" ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу намрын мод тарих ажилд дүүргийг дайран өнгөрөх Мянганы зам дагуу 110 ш 6 настай улиас модонд үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн компост бордоог ашигласан ажлын явцыг паркийн инженер мэргэжилтнүүд үзэж, зөвлөгөө өгөв.</p>	100%

5	Хүнд хөгжлийн хөтөлбөр үйлдвэрийн үндэсний үндэсний	<p>УУХҮЯ-ны сайдын 2019 оны А/180 дугаар тушаалаар батлагдсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан “Хүнд үйлдвэрийг дэмжих хууль”-ийн төслийн анхан шатны хэлэлцүүлэгт ҮТА-ны Ахлах мэргэжилтэн хамрагдан, тандалт судалгааны санал асуулгад саналыг боловсруулан хүргүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Мөн Хүнд үйлдвэрийг дэмжих хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан УУХҮЯ, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтнүүдэд паркийн хүнд үйлдвэрийн бүсийн байршил, төлөвлөсөн үйлдвэр, дэд бүтцийг холбох нөхцөл байдалтай газар дээр нь танилцуулж зохих мэдээллийг өгөв.</p>	80%																										
6	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг хангаж, <a href="https://erp.ulaanbaatar.mn/">https://erp.ulaanbaatar.mn/</a> системийн дэд системүүдийн сургалтуудыг албан хаагчдад явуулж, хэрэглээг дээшлүүлэн ажиллаж байна. Мөн дээрх журмын дагуу Үндсэн хөрөнгө бүртгэлийн дэд системд байгууллагын албан хаагч бүрийн эзэмшиж байгаа үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг оруулсан. Цаашид шилжилт хөдөлгөөнийг тухай бүр оруулж, хяналт тавьж ажиллахаар хариуцсан албан хаагчид үүрэг болгож, хөдөлмөрийн гэрээнд тусгасан.</p> <p><a href="https://edoc.ulaanbaatar.mn/">https://edoc.ulaanbaatar.mn/</a> дэд системийн ашиглалт:</p> <table border="1" data-bbox="618 980 1711 1338"> <thead> <tr> <th rowspan="2">Ирсэн бичиг</th> <th rowspan="2">Хариутай бичиг</th> <th rowspan="2">Хариугүй бичиг</th> <th colspan="2">Шийдвэрлэлт, хувь</th> <th rowspan="2">Хугацаа</th> </tr> <tr> <th>Хариутай</th> <th>Хариугүй</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Захиргааны алба</td> <td>3</td> <td>10</td> <td>100%</td> <td>100%</td> <td>5,23 хоног</td> </tr> <tr> <td>Үйлдвэрлэл, технологийн алба</td> <td>10</td> <td>8</td> <td>87,50%</td> <td>90%</td> <td>3,39 хоног</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>13</td> <td>18</td> <td>93,75%</td> <td>95%</td> <td>4,31 хоног</td> </tr> </tbody> </table> <p>Дүүргээс зохион байгуулсан “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах аян”-ы хүрээнд хийсэн ажлын тайланг гаргаж 188 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p>	Ирсэн бичиг	Хариутай бичиг	Хариугүй бичиг	Шийдвэрлэлт, хувь		Хугацаа	Хариутай	Хариугүй	Захиргааны алба	3	10	100%	100%	5,23 хоног	Үйлдвэрлэл, технологийн алба	10	8	87,50%	90%	3,39 хоног	Нийт	13	18	93,75%	95%	4,31 хоног	100%
Ирсэн бичиг	Хариутай бичиг	Хариугүй бичиг				Шийдвэрлэлт, хувь			Хугацаа																				
			Хариутай	Хариугүй																									
Захиргааны алба	3	10	100%	100%	5,23 хоног																								
Үйлдвэрлэл, технологийн алба	10	8	87,50%	90%	3,39 хоног																								
Нийт	13	18	93,75%	95%	4,31 хоног																								

7	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2	МУИС-ийн Эрдэм шинжилгээ хамтын ажиллагааны дэд захирал шинээр томилогдсонтой холбогдуулан хамтын ажиллагааг эхлүүлэх асуудлаар уулзалт зохион байгуулсны дагуу Санамж бичгийн төслийг цахимаар хүргүүлэв.	100%
8	Иргэдийн оролцоотой хөгжлийн жил" болон "Иргэдийн амьдрах орчныг сайжруулах жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	<p>Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх танхимын сургалтыг 13 байгууллагын 312 ажилтанд зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2019.11.01-нд "Багануур-Ус" ОНӨААТҮГ - 52 ажилтан</li> <li>• 2019.11.01-нд дүүргийн 3 дугаар хороо - 26 ажилтан</li> <li>• 2019.11.04-нд "Гэрэл-Ирээдүй" МСҮТ - 16 ажилтан</li> <li>• 2019.11.05-нд 2 дугаар хороо - 15 ажилтан</li> <li>• 2019.11.06-нд "Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨХХК - 9 ажилтан</li> <li>• 2019.11.06-нд "Мобиком корпораци" Багануур салбар - 5 ажилтан</li> <li>• 2019.11.11-нд "Мон цахим" ХХК - 24 ажилтан</li> <li>• 2019.11.13-нд "Багануур Дулааны станц" ТӨХК - 35 ажилтан</li> <li>• 2019.11.13-нд Боловсролын хэлтэс - 14 ажилтан</li> <li>• 2019.11.15-нд БЗӨБ-ийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Багануур салбар - 14 ажилтан</li> <li>• 2019.11.16-нд "Багануур Юнител" салбар - 4 ажилтан</li> <li>• 2019.11.22-нд ЦДҮС ТӨХК-ийн ЗӨБС - 50 ажилтан</li> <li>• 2019.11.29-нд Багануур цахилгаан механикийн үйлдвэр ХХК - 48 ажилтан</li> </ul> <p>"Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст, компост бордоо хийх аргачлал" сэдэвт танхимын сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулахтай холбогдуулан Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Улаанбаатар төмөр замын Багануур өртөө, Шуудан үйлчилгээний газар болон Албан бус-Насан туршийн боловсролын төв, Хилийн инженер техникийн 0252 дугаар тусгай анги, Эрүүл мэндийн төвд албан бичгийг хүргүүлэн сургалт явуулах өдрийг тохиролцож хуваарь гарган ажиллаж байна.</p>	100%
9	Багануур дүүргийн ЗДТГ-тай хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө	Дүүргийн ЗДТГ-тай хамтран баталсан 2018-2019 оны төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст компост бордоо хийх сургалтыг дүүргийн хороодод явуулсан тухай тайлан болон цаашид авах арга хэмжээний саналаа ЗДТГ-т хүргүүлсэн.	100%

10	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1, 5.1	<p>Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн явцыг удирдлагад танилцуулсан.</p> <p>Мөн байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу гаргаж байна.</p>	100%
11	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7.4.	<p>Байгууллагын орон тооны бус салбар зөвлөл, комиссуудын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг урьдчилсан байдлаар дүгнэж, хамт олны хурлаар хэлэлцүүлэв. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн түвшин:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Даргын зөвлөл - 100%</li> <li>• Ёс зүйн зөвлөл – 90%</li> <li>• Дотоод хяналт шалгалтын комисс – 90%</li> <li>• Баримт бичиг нягтлан шалгах комисс – 95%</li> <li>• Өмч хамгаалах байнгын комисс – 100%</li> <li>• Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар зөвлөл – 100%</li> <li>• Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл – 100%</li> </ul>	100%
<b>Нэмэлт ажил</b>			
1		<p>Казахстан улсаас ирсэн Эрдсийг иж бүрэн боловсруулах судалгааны төвийн удирдлага, бизнесийн төлөөлөгчидтэй Засаг дарга дээр хийсэн уулзалтад оролцон Багануурын уурхайн нүүрс, шорооны хаягдал холимогыг ашиглаж хөнгөнцагаан, цахиурын Ферро гаргах боломжийг судлах асуудлаар санал солилцож, Багануурын уурхайтай танилцуулж нүүрсний үнсний шинжилгээний дүн болон нүүрс шорооны холимогын дээжийг авч хүргүүлэх ажлыг зохион байгуулав.</p>	100%
2		<p>Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд :</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн бүтээлч ажлын төлөвлөгөө”, “Хотын иргэдийн амьдрах орчныг сайжруулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын биелэлт болон ойн хүрээнд хийж гүйцэтгэсэн бүтээлч ажлын тайлан гаргаж НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.</li> </ul>	100%

	<p>- Нийслэл хот байгуулагдсаны 380 жил, Үйлдвэрлэл, технологийн паркууд байгуулагдсаны 5 жилийн ойг тохиолдуулан “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-аас санаачлан зохион байгуулсан “ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ БА ГАРЦ ШИЙДЭЛ” сэдэвт хэлэлцүүлэгт паркийн нийт ажилтнууд оролцсон. Тус уулзалт хэлэлцүүлгийн хүрээнд зохион байгуулсан Спорт өдөрлөгт амжилттай оролцож тэргүүн байранд шалгарсан.</p>	
3	Нийслэлийн ЗДТГ-ын 03/5443 дугаар албан бичгээр ирүүлсэн Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл бэлтгэх зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулж, цаашид анхаарч ажиллахыг хариуцсан албан хаагчид үүрэг болгов.	100%
4	Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ыг боловсруулж байгаатай холбогдуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой паркийн төсөл, хөтөлбөрүүдийн саналаа Концессын тухай хууль болон бусад хууль, журамд заасны дагуу боловсруулан зардал ашигийн тооцооны хамтаар НШУҮИГ-т хүргүүлэв.	100%
5	Нийслэлийн Дотоод аудитын хорооны 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолын дагуу манай байгууллагад хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлсэн.	100%
6	Нийслэл дэх Төрийн аудитын газар, Монголын Үндэсний Дотоод Аудиторуудын холбоо ТББ-тай хамтран зохион байгуулсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, аудит, хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлийн тухай сургалтад паркийн дарга, нягтлан бодогч нар 2019.11.29-нд хамрагдав.	100%
7	Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу 2020 оны эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажил хийгдэж байгаатай холбогдуулан судалгаанд оролцож байгууллагын мэдээллийг Нийслэлийн Дотоод аудитын газарт хүргүүлэв.	100%
8	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санаачилан зохион байгуулсан “Нэг хот – Нэг стандарт” нийслэлийн анхдугаар зөвлөгөөнд оролцож, “Стандарттай хот” болзолт уралдааны шалгуур үзүүлэлтэд тусгуулах санал, тооцох аргачлалыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.	100%

9	Архивын ерөнхий газраас Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын 7-д заасны дагуу боловсруулагдсан “Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтанд мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт”-тэй танилцаж байгууллагын ББНШК-ын хурлаар хэлэлцэн саналаа хүргүүлсэн.	100%
10	Монгол улсын Статистикийн тухай хуулийн дагуу “Хүн ам орон сууцны ээлжит тооллого” явуулах бэлтгэл ажлын хүрээнд байгууллагын албан хаагчдын мэдээллийг нягтлан дүн мэдээг дүүргийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн.	100%
11	2019 онд үр бүтээлтэй ажилласан 3 албан хаагчийг Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнуулахаар хамт олны санал гарсан тул шагналын материалыг журмын дагуу бүрдүүлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.	100%
12	Багануур дүүргийн ЗДТГ-аас 2019.11.16-нд Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг угтан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, хөгжүүлэх зорилгоор “Имако консалтинг институт”-тай хамтран зохион байгуулсан “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА ХАНДЛАГА, БАГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА” сэдэвт сургалтад Ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ хамрагдаж, байгууллагын албан хаагч нарт сургалтын мэдээллийг танилцууллаа.	100%
13	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс санаачлан дүүргийн салбар зөвлөл болон Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн холбоотой хамтран дүүргийн иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг чадавхжуулах” сэдэвт сургалтыг 2019.11.15-нд зохион байгуулсан. Тус сургалтад Үйлдвэрлэл, технологийн албаны 3 инженер хамрагдлаа.	100%
14	Монгол улсад орчин цагийн архивын салбар үүсэж хөгжсөний 92 жилийн ойг тохиолдуулан 2019.11.29-нд зохион байгуулагдах сургалт, танин мэдэхүй, спортын арга хэмжээнд Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн М.Мөнхдулам оролцов.	100%
15	Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд албан хаагчдын эрүүл, аюулгүй ажиллах, суралцах таатай орчныг бүрдүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг бэлтгэж 2019.11.25-ны 200 дугаартай албан бичгээр дүүргийн Эрүүл мэндийн төвд хүргүүлэв.	100%

16	Дүүргийн нутаг дэвсгэрт 2019.11.11-нд их цас орсонтой холбогдуулан Захирагчийн ажлын албанаас заасан хуваарьт газрын цасыг цэвэрлэж, тайланг албаны утсаар мэдээлэв.	100%
----	--	------

ТАЙЛАН ХЯНАСАН:  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МИЧИД-ЭРДЭНЭ